

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Байршил: Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Эхлэх хугацаа: 2026/05/26

Дуусах хугацаа: 2026/06/26

Ажил эхлэх хугацаа: 2026/06

Цалин: Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

ЦАХИЛГААНЧИН

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

- Байгууллагын цахилгаан хангамжийн систем болон тоног төхөөрөмжүүдийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах;
- Цахилгаан байгууламжуудын урьдчилан сэргийлэх болон гэнэтийн эвдрэлийн үед хийгдэх засвар үйлчилгээг аюул осолгүй, цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх;
- Сургуулийн бусад шаардлагатай үйл ажиллагаанд оролцох, дэмжлэг үзүүлэх;
- Ээлжинд гарч ажиллах.

Тавигдах шаардлага:

- Цахилгаанчны мэргэжлээр төгссөн;
- Мэргэжлээрээ 2-оос дээш жил ажилласан туршлагатай;
- Харилцааны соёлтой;
- Бие даан болон багаар ажиллах чадвартай;
- Цахилгаанчны мэргэжлээр бакалаврын зэрэгтэй болон англи хэлний мэдлэгтэй бол давуу тал болно.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орох өргөдөл
- Товч намтар – CV
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа

Холбоо барих:

Та баримт бичгээ нэг PDF файл болгон эмхэтгэж recruitment@gmit.edu.mn хаягаар бидэнд ирүүлнэ үү.

Цахим хуудас: www.gmit.edu.mn

Бидэнтэй +976 7023-2090 тоот утсаар болон цахим хаягаар холбогдох боломжтой.

Жич: Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярилцлагад урих болно.